

## **10 дугаар бүлгийн**

### **9 дүгээр хавсралт**

#### **10.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт дурдсан арга хэмжээнд хамаарах хадгалах нөхцөл**

(1 дэх хэсэг нь япон, англи хэлээр байх ба  
энэхүү хавсралтын салшгүй хэсэг болно)

#### **2 дахь хэсэг**

#### **МОНГОЛ УЛСЫН ЖАГСААЛТ**

1. Монголын талын жагсаалт нь 10.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу тодорхой салбар, дэд салбар, эсхүл үйл ажиллагааны хувьд одоо мөрдөж буй зохицуулалтаа хадгалах, эсхүл шинэ болон илүү хязгаарлалт тогтоох эрхээ монголын тал хадгалах нөхцөлийг тусгасан бөгөөд эдгээр нь дор дурдсан зүйлээр хүлээсэн үүрэгтэй үл нийцнэ:

- (a) 10.3 дугаар зүйл;
- (b) 10.4 дугаар зүйл;
- (c) 10.7 дугаар зүйл.

2. Хадгалах нөхцөл бүр дараахь бүрэлдэхүүн хэсгийг агуулна:

- (a) “Салбар” гэх нэр томьёо нь тухайн хадгалах нөхцөл хамаарах ерөнхий салбарыг хэлнэ;
- (b) “Дэд салбар” гэх нэр томьёо нь тухайн хадгалах нөхцөл хамаарах тодорхой салбарыг хэлнэ;
- (c) “Хадгалах нөхцөлийн төрөл” гэх нэр томьёо нь 1 дэх хэсэгт дурдсан хадгалах нөхцөлд хамаарах үүргийг тодорхойлно;
- (d) “Тайлбар” гэх нэр томьёо нь 1 дэх хэсэгт дурдсан үүрэгтэй холбоотойгоор хадгалах нөхцөлд хамаарах одоо мөрдөж буй арга хэмжээний үл нийцэх байдлыг тодорхойлно;

- (e) “мөрдөж буй арга хэмжээ” гэх нэр томъёо нь ил тод байх зорилгоор хадгалах нөхцөлд хамрагдах салбар, дэд салбар болон үйл ажиллагаанд одоо мөрдөж байгаа арга хэмжээг тодорхойлно.

3. Хадгалах нөхцөлийн тайлбарт тухайн хадгалах нөхцөлийн бүх бүрэлдэхүүн хэсгийг авч үзнэ. “Тайлбар” хэсгийг бусад хэсгээс давуу байдлаар авч үзнэ.

1. Салбар: Бүх салбар

Дэд салбар:

Хадгалах нөхцөлийн төрөл: Үндэсний нөхцөл (10.3 дугаар зүйл)

Үйл ажиллагааны шалгуурт тавигдах хориг (10.7 дугаар зүйл)

Тайлбар:

Төрийн өмчит аж ахуйн нэгж болон засгийн газрын харьяа байгууллагын эзэмшлийн хувьцааг, эсхүл үндсэн хөрөнгийг шилжүүлэх болон тараах үед Монгол Улс дараахь эрхийг хадгална:

(a) Дээр дурдсан хувьцаа болон хөрөнгөд Японы хөрөнгө оруулагчдын эсхүл тэдний хөрөнгө оруулалтын эзэмшлийг хориглох эсхүл хязгаарлах;

(b) Дээр дурдсан хувьцаа болон хөрөнгийг эзэмшсэнээр холбогдох аливаа аж ахуйн нэгжийг хянах Японы хөрөнгө оруулагчдын эсхүл тэдний хөрөнгө оруулалтын чадамжийг хязгаарлах;

(c) Холбогдох аливаа аж ахуйн нэгжийн удирдлага, менежер эсхүл захирлуудын зөвлөлийн гишүүдийн иргэншилтэй холбоотой аливаа арга хэмжээг батлах эсхүл хэрэгжүүлнэ.

Мөрдөж буй арга хэмжээ

2. Салбар:	Бүх салбар
Дэд салбар:	Үндэсний нөхцөл (10.3 дугаар зүйл)
Хадгалах нөхцөлийн төрөл:	Нэн тааламжтай үндэстний нөхцөл (10.4 дүгээр зүйл)
	Үйл ажиллагааны шалгуурт тавигдах хориг (10.7 дугаар зүйл)
Тайлбар:	Монгол Улс нь үндэсний аюулгүй байдлаа хангах болон тэнцвэржүүлэх зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчдын тухайн нэг салбарт оруулсан, худалдан авсан эсхүл өргөжүүлсэн хөрөнгө оруулалтын хэмжээтэй холбоотой аливаа арга хэмжээг батлах эсхүл хэрэгжүүлэх эрхээ хадгална.
Мөрдөж буй арга хэмжээ	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (Улсын Их Хурлын 2010 оны 48 тоот тогтоол)

3. Салбар:	Хүнсний үйлдвэрлэл
Дэд салбар:	Стратегийн хүнсний бүтээгдэхүүн
Хадгалах нөхцөлийн төрөл:	Үндэсний нөхцөл (10.3 дугаар зүйл) Үйл ажиллагааны шалгуурт тавигдах хориг (10.7 дугаар зүйл)
Тайлбар:	Монгол Улс нь малын мах, сүү, гурил, буудай, үр тариа болон ундны ус зэрэг хэрэглэгчдийнэрэлтийн дийлэнх хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангуулах аливаа арга хэмжээг батлах эсхүл хэрэгжүүлэх эрхээ хадгална.
Мөрдөж буй арга хэмжээ	2012 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн Хүнсний тухай хууль, 3.1 дүгээр зүйл  Засгийн газрын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Засгийн газрын 2011 оны 114 тоот тогтоол) Хавсралт 1

4. Салбар: Үйлдвэрлэл
- Дэд салбар: Ноос болон ноолуурын үйлдвэрлэл
- Хадгалах нөхцөлийн төрөл: Үндэсний нөхцөл (10.3 дугаар зүйл)  
Үйл ажиллагааны шалгуурт тавигдах хориг (10.7 дугаар зүйл)
- Тайлбар: Монгол Улс нь ноос болон ноолуурын үйлдвэрлэл дэх хөрөнгө оруулалттай холбоотой аливаа арга хэмжээг батлах эсхүл хэрэгжүүлэх эрхээ хадгална.
- Мөрдөж буй арга хэмжээ

5. Салбар:	Тээвэр
Дэд салбар:	Төмөр замын тээвэр
Хадгалах нөхцөлийн төрөл:	Үндэсний нөхцөл (10.3 дугаар зүйл) Нэн тааламжтай үндэстний нөхцөл (10.4 дүгээр зүйл) Үйл ажиллагааны шалгуурт тавигдах хориг (10.7 дугаар зүйл)
Тайлбар:	Монгол Улс нь төмөр замын тээврийн салбарт хийх хөрөнгө оруулалтын зөвшөөрөлтэй холбоотой аливаа арга хэмжээг батлах эсхүл хэрэгжүүлэх эрхээ хадгална.
Мөрдөж буй арга хэмжээ	Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоол (2010 оны 32 тоот)

6. Салбар:	Иргэний нисэх
Дэд салбар:	Арилжааны зорилго бүхий агаарын тээвэр
Хадгалах нөхцөлийн төрөл:	Үндэсний нөхцөл (10.3 дугаар зүйл) Үйл ажиллагааны шалгуурт тавигдах хориг (10.7 дугаар зүйл)
Тайлбар:	Монгол Улс нь иргэний нисэх болон агаарын тээврийн салбарт хийх хөрөнгө оруулалттай холбоотой аливаа арга хэмжээг батлах эсхүл хэрэгжүүлэх эрхээ хадгална.
Мөрдөж буй арга хэмжээ	



7. Салбар:	Барилга
Дэд салбар:	Үл хөдлөх хөрөнгийн бүтээн байгуулалт болон худалдаа
Хадгалах нөхцөлийн төрөл:	Үндэсний нөхцөл (10.3 дугаар зүйл) Үйл ажиллагааны шалгуурт тавигдах хориг (10.7 дугаар зүйл)
Тайлбар:	Монгол Улс нь үл хөдлөх хөрөнгийн бүтээн байгуулалт болон өмчлөл, түүний худалдаанд гадаадын иргэн болон гадаадын хуулийн этгээдийн хийх хөрөнгө оруулалтын зөвшөөлөлтэй холбоотой аливаа арга хэмжээг батлах эсхүл хэрэгжүүлэх эрхээ хадгална.
Мөрдөж буй арга хэмжээ	

8. Салбар:	Харилцаа холбоо
Дэд салбар:	Радио болон телевизийн үйлчилгээ
	Радио болон телевизийн дамжуулах үйлчилгээ
Хадгалах нөхцөлийн төрөл:	Үндэсний нөхцөл (10.3 дугаар зүйл)
	Үйл ажиллагааны шалгуурт тавигдах хориг (10.7 дугаар зүйл)
Тайлбар:	Монгол Улс нь радио, телевизийн үйлчилгээ болон радио, телевизийн дамжуулах үйлчилгээний салбарын хөрөнгө оруулалттай холбоотой аливаа арга хэмжээг батлах эсхүл хэрэгжүүлэх эрхээ хадгална.
Мөрдөж буй арга хэмжээ	

9. Салбар:	Уул уурхай
Дэд салбар:	
Хадгалах нөхцөлийн төрөл:	Үйл ажиллагааны шалгуурт тавигдах хориг (10.7 дугаар зүйл)
Тайлбар:	Монгол Улс нь уул уурхайн салбарт хийх хөрөнгө оруулалтын зөвшөөрөлтэй холбоотой аливаа арга хэмжээг батлах эсхүл хэрэгжүүлэх эрхээ хадгална.
Мөрдөж буй арга хэмжээ	2006 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн Ашигт малтмалын тухай хууль, (34 болон 43 дугаар зүйл)  2013 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн Хөрөнгө оруулалтын тухай хууль, (21 болон 22 дугаар зүйл)

10. Салбар: Бүх салбар

Дэд салбар:

Хадгалах нөхцөлийн  
төрөл: Үндэсний нөхцөл (10.3 дугаар зүйл)

Нэн тааламжтай үндэстний нөхцөл  
(10.4 дүгээр зүйл)

Тайлбар: Үндэсний нөхцөл болон нэн тааламжтай  
үндэстний нөхцлийг татаастай холбоотойгоор  
Японы хөрөнгө оруулагчид болон тэдгээрийн  
хөрөнгө оруулалтад олгохгүй байж болно.

Мөрдөж буй арга  
хэмжээ